| № | Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга | Тодруулгын хариу |
|---|---|---|
| 1 | ТЭЗҮ шинэчлэх тухай: Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд санал ирүүлэх сонирхогч этгээд нь ямар санал ирүүлэх талаар: Тендерийн баримт бичгийн 2-р бүлгийн 13.2.6-д Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд санал ирүүлэх сонирхогч этгээд нь батлагдсан техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах шийдэл, саналыг ирүүлнэ гэж тендерийн баримт бичигт заасан байна. Харин Техникийн тодорхойлолтын 9 дүгээр хуудасны 4.1-д шинэчилсэн ТЭЗҮ-ийн дагуу санал, шийдлийг боловсруулна гэж заасан ба Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барих төслийн ТЭЗҮ шинэчлэлт, ажлын тайлбарын хэсэгт ТЭЗҮ-д шинэчлэх хэсгүүд оруулсан байна. Бид батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу өөрчлөлт санал оруулах шаардлагатай юу, эсвэл ТЭЗҮ-ийн шинэчлэлийн тодорхойлолтонд заасны дагуу ТЭЗҮ-ийн баримт бичгүүдийг шинэчлэх шаардлагатай юу, эсвэл нэгдүгээр үе шатанд хоёуланг нь хийх шаардлагатай эсэх талаар дэлгэрэнгүй тодорхой тайлбар өгнө үү? | Тухайн оролцож буй этгээд нэгдүгээр шатанд заавал нэмэлт санал ирүүлэх шаардлагагүй. |
| 2 | Сонгон шалгаруулалтын тухай: Сонгон шалгаруулалтын тухайд: Тендерт оролцогчид нэгдүгээр үе шатанд урьдчилсан сонгон шалгаруулалтад орох шаардлагагүй гэж ойлгож байна. Хоёрдугаар шатанд урьдчилсан сонгон шалгаруулалт зохион байгуулах уу? Сонгон шалгаруулалтын хоёр дахь шатанд тендерт оролцогч нь хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтын холбогдох шаардлагыг хангахын тулд эхний шатанд оролцоогүй компаниудтай хамтран оролцож болох эсэхийг тодруулж өгнө үү. | Нэгдүгээр шатанд оролцох сонирхлоо илэрхийлсэн оролцогчдын саналд үндэслэн хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж нэгдүгээр шатанд оролцох сонирхлоо илэрхийлсэн бүх этгээдүүдэд илгээх болно. Нэгдүгээр шатанд оролцох сонирхолоо илэрхийлээгүй этгээд нь хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй. /ТШЗ 13.2.6 дугаар заалтаас үзнэ үү/ |
| 3 | Тендерт оролцогчдод тавигдах тодорхой шаардлага, стандартын тухай: Хавсралт баримт бичгийн харгалзан, үнэлэх техникийн мэдлэг, санхүүгийн чадавх холбогдох туршлагын дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй. Техникийн мэдлэг, санхүүгийн чадавх, холбогдох туршлагыг нотлохын тулд тендерт оролцогчдод тавигдах тодорхой шаардлага, стандартын талаар тодруулж өгнө үү. | Техникийн мэдлэг, санхүүгийн чадавх, холбогдох туршлагыг нотлохын тулд тендерт оролцогчдод тавигдах тодорхой шаардлага, стандартын талаар тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд нарийвчлан тодорхой заах өгнө. |
| 4 | Баримтлах стандартын талаар: Баримтлах стандарын талаар: Аль улсын стандартыг баримтлах вэ? АНУ, Европ аль эсвэл Хятад улсын стандарт зэрэг тодорхой тайлбар өгнө үү?. | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад хавсаргагдана. |

| | | |
|---|---|---|
| 5 | ТЭЗҮ-ийн талаар: ТЭЗҮ /шинэчилсэн ТЭЗҮ/ -гийн баримт бичгийг Захиалагч тал батлуулсан юм уу? Батлагдсан бол ТЭЗҮ-гийн ямар бичиг баримт материал байгаа вэ? Бидэнд ТЭЗҮ-г баталсан бичиг баримт болон бусад мэдээлэл байх эсэх талаар тодорхой тайлбар өгнө үү? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад хавсаргагдана. |
| 6 | Техник стандартын талаар: Төслийн гол техникийн стандарт нөхцөл нь тендерийн баримт бичигт танилцуулсан техникийн шаардлагын дагуу л байх уу, тодорхой хэмжээнд сайжруулалт тохируулга хийгдэх үү? | Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд санал ирүүлэх сонирхогч этгээд нь батлагдсан техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах шийдэл, саналыг ирүүлнэ. Тусгайлан өгөх санал, шийдэлгүй тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо ирүүлж болно. /ТШЗ 13.2.6 дугаар заалтаас үзнэ үү/ |
| 7 | Төслийн нарийвчилсан мэдээлэлийн тухай: Төслийн талаар илүү сайн мэдээлэл судалгаатай байлгахын тулд төслийн нарийвчилсан мэдээлэл шаардлагатай? Жишээ нь ТЭЗҮ-гийн хавсралт зургийг өгөх үү. Трассын дагуух байр зүйн тофографик зураг/Image map/ гэх мэтийг өгөх үү? Төслийн хэмжээнд байгаа нүүлгэн шилжүүлэх, газар чөлөөлөлтийн асуудлыг аль хэдийн тогтсон уу хэрхэн шийдвэрлэсэн бэ?<br><br>Ямар шатандаа байгаа вэ, хэрвээ шийдсэн бол байгаль орчны үнэлгээ, зам тээврийн /төлөвлөлт ба шаардлага/ зэргийг судлах шаардлагатай юу? Мөн геологийн материалыг, төлөвлөлтийн зураг, тухайн бүсэд байгаа хязгаарлах шаардлагатай барилга байгууламж болон шугам сүлжээний мэдээллийн талаар тодорхой тайлбар өгнө үү? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад хавсаргагдана. |
| 8 | Тендер шалгаруулалтын хэл: Баталгаат орчуулгын товчооны орчуулгыг хүлээн зөвшөөрөх үү. Баталгаат орчуулгаар орчуулсан тохиолдолд тендерийн шаардлагыг хангасан гэж үзэх үү. | Тендер шалгаруулалтын урилга, тендерийн баримт бичгийг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендерт оролцогчдын ирүүлэх тендер Монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг зохих ёсоор орчуулсан баталгаат орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ. |

| | | |
|---|---|---|
| 9 | Сонгон шалгаруулалтын тухай: Тендерийн саналыг тордруулах шаардлагатай байна, ялангуяа эхний үе шатанд техникийн санал шаардлагатай эсэхийг тодруулж өгнө үү. | Нэгдүгээр шатанд оролцох сонирхлоо илэрхийлсэн оролцогчдын саналд үндэслэн хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж нэгдүгээр шатанд оролцох сонирхлоо илэрхийлсэн бүх этгээдүүдэд илгээх болно. Нэгдүгээр шатанд оролцох сонирхолоо илэрхийлээгүй этгээд нь хоёрдугаар шатны сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй. /ТШЗ 13.2.6 дугаар заалтаас үзнэ үү/ |
| 10 | To ensure we have a comprehensive understanding of the tender requirements, we would appreciate clarification on the following points:<br><br>What is the expected contract structure? While the feasibility report defines three models with a focus on PPP, we would like to understand your specific expectations for the contract structure. | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад тусгаж өгнө. |
| 11 | Do you have a draft contract available? If so, could you provide the head terms? | Та бүхэн тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 13.2.6, 16.2.1, 25.3 дахь хэсэгт тус тус заасны дагуу тендерийн материал бэлтгэн оролцоно уу. Бусад шалгуур үзүүлэлтийг нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатанд тусгаж зарлана. |
| 12 | What are the expected tender submission documents? Are you expecting a letter of interest or a more comprehensive submission? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад тусгаж өгнө. |
| 13 | What criteria will be used to shortlist companies? Will factors such as experience, financial strength, quality, and capacity be evaluated? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад тусгаж өгнө. |
| 14 | The clarification request mentions a payment requirement, but we could not find details in the tender documents. Could you clarify this requirement? Is it related to procurement system registration? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад тусгаж өгнө. |

| | | |
|---|---|---|
| 15 | The feasibility report indicates that some financing will be provided by IFIs. Are there existing agreements with International Financial Institutions (IFIs) or Export Credit Agencies (ECAs)? Will the contractor be expected to secure any financing? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад тусгаж өгнө. |
| 16 | Are there any content requirement that must be sourced from foreign countries? | Нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны сонгон шалгаруулалтад тусгаж өгнө. |
| 17 | Манай компанийн зүгээс 2013 оны EPC тендерийн 1-р үе шатанд сонирхол илэрхийлэх хүсэлт (EOI), ажлын даалгавар (TOR), болон ТЭЗҮ-д нарийвчилсан судалгааны үр дүнд шаардлагыг хангахуйц, өрсөлдөх чадвартай саналыг бэлтгэхэд илүү хугацаа хэрэгтэй байгаа нь тогтоогдсон байна.<br><br>Иймээс сонирхол илэрхийлэх хүсэлт ирүүлэх хугацааг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүртэл 1 сараар сунгаж өгөхийг хичээнгүйлэн хүсье. | Захиалагчийн зүгээс тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатны тендер хүлээн авах хугацааг хуанлийн 67 хоногоор зарласан. Тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах боломжгүй.<br><br>Тендер шалгаруулалтын нэгдүгээр үе шатанд санал ирүүлэх сонирхогч этгээд нь батлагдсан техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулах шийдэл, саналыг ирүүлнэ. Тусгайлан өгөх санал, шийдэлгүй тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцох сонирхлоо ирүүлж болно. |